Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ГАДААД ХАРИЛЦАА, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БАТЦЭНГЭЛИЙН ЛХАГВАНЯМЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1.** “БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БОДЛОГО, СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХОЛБОГДОХ СУДАЛГАА ХИЙХ, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ” | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Биеийн тамир, спортын салбарын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд шаардлагатай баримт бичгийг боловсруулж хүргүүлэх | Боловсруулах баримт бичиг | - | Нэгжийн чиг үүрэгтэй холбоотойгоор барим бичгийн бүрдэл хангагдсан байна. | Стратеги төлөвлөлттэй холбоотойгоор ирүүлсэн загвараар мэдээллийг боловсруулан Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. | 03.01 – 09.30 | 100 |
| 2. | Арга хэмжээ 1.2. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг тодорхойлох зорилгоор байгуулагдсан сорилын төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн системд | Арга хэмжээний тоо | - | 1 арга хэмжээ зохион байгуулсан байх | Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсээс зохион байгуулсан Бие бялдрын түвшнийг хянах сорилын төвийн тоног төхөөрөмжийг нийлүүлэгч Андромедиа ХХК-тай хийх уулзалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны | 02.15 – 11.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | | | | Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын шинжээч С.Мөнх-Эрдэнийн хамтаар салбарын мэдээллийн сангийн ашиглалт, хөгжүүлэлтийн хүрээнд хийгдэх өөрчлөлт, засвар үйлчилгээ талаар санал танилцуулсан. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Улсын хэмжээнд зохион байгуулагдах Спортын наадмуудын мэдээллийг салбарын мэдээллийн нэгдсэн цахим санд бүрдүүлэх ажлыг зохион байгуулах | Спортын наадмын тоо | - | 3 наадмын цахим сангийн бүрдүүлэлт бүрдүүлэлт хийсэн байх | Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмын шигшээ шатанд оролцогч 20 байгууллагын нийт 491 албаны төлөөлөл, дасгалжуулагч, тамирчдын цахим бүртгэлийг хийж, спортын 7 төрлийн 18 байгууллагын 242 медалийн үр дүнгийн мэдээллийг байгууллагын веб сайт дээр ил тод байршуулан наадмын үйл ажиллагааны цахим санг бүрдүүлэн ажиллалаа.<br>Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатанд орон нутгийн түвшинд зохион байгуулж нийт 11549 тамирчин, дасгалжуулагчийн мэдээллийг бүрдүүлэн ажилласан бол шигшээ шатанд байгууллагын нийт 30 байгууллагын 6186 албаны төлөөлөл, дасгалжуулагч, тамирчдын цахим бүртгэлийг хийн наадмын үр дүнгийн мэдээллийг байршуулан наадмын үйл ажиллагааны цахим санг бүрдүүлсэн. Наадмын хөтөлбөрт багтсан үндсэн төрлийн спортын 22 төрөл, | 02.15 – 11.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 5 төрлийн нийт 30 байгууллагын 947 медалийн үр дүнг цахимаар гаргасан.<br>Салбарын цахим сангийн ашиглалтын хүрээнд Монголын бүх ард түмний зуны спортын XVI наадмын цахим бүртгэлийг үндсэн 20 спортын төрөл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8 спортын төрлөөр Улаанбаатар хот, Баянхонгор аймагт нэгэн зэрэг 20 байршилд зохион байгуулахад 30 байгууллагын 329 дасгалжуулагч, 3258 тамирчин хамрагдан 879 багц медалийн төлөөх өрсөлдөөнийг 425 шүүгч дэнслэн ажиллав. Баянхонгор аймагт спортын 17 төрлийн тэмцээнийг 13 байршилд зохиоход 2150 тамирчин, 243 дасгалжуулагч, 294 шүүгч ажиллаж, мөн Улаанбаатар хотод спортын 11 төрлийн тэмцээнийг 7 байршилд зохиоход 1108 тамирчин, 86 дасгалжуулагч, 131 шүүгчийг тус тус цахим бүртгэл хийн ажиллаж тус наадмын шигшээ шатны үр дүнг мэдээллийг ил тод мэдээлэн ажиллалаа. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 1.4. Биеийн тамир, спортын салбарын нэгдсэн цахим сангийн хүрээнд спортын холбооны цахим мэдээллийн системийн цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай засвар үйлчилгээг үзүүлэн ажиллах | Цахим санд бүртгэлтэй спортын холбооны тоо | 35 спортын холбоо | 38 спортын холбоо | Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн санд Монголын пара волейболын холбоо, Монголын уулчдын үндэсний холбоо, Монголын хөнгөн атлетикийн холбоо, Монголын сагсан бөмбөгийн холбоо, Дрон нисгэгчдийн холбоо гээд нийт 5 холбооны цахим хуудсыг үүсгэж, хариуцсан албан хаагчдад шаардлагатай мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. | 03.01 – 12.15 | 100 |
| 5. | Арга хэмжээ 1.5. Олон улсад амжилттай хэрэгжсэн сайн туршлагаас салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг судлах | Баримт бичгийн тоо | - | 1 баримт бичиг | Спортын эрхийн бичгийн мэдээллийн системийн ажлын даалгаврыг боловсруулах хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд Яамны цахим шилжилтийн асуудал хариуцсан нэгжийн төлөөлөлтэй Биеийн тамир, спортын улсын хорооны даргатай хамт уулзалт хийж, уулзалтын мөрөөр Спортын эрхийн бичгийн мэдээллийн системийг хөгжүүлэх баримт бичгийн төслийг хүргүүлэн ажиллав. | 04.15 – 12.15 | 100 |
| **ЗОРИЛТ 2.** “САЛБАРЫН УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ХЭВИЙН АЖИЛЛАГАА, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ” | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 2.1. Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн цахим сангийн техник хэрэгсэл, программ хангамжийн шинэчлэлийг тухай бүр хийх, техник, тоног төхөөрөмжийн өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэх | Мэдээллийн системийн тасралтгүй ажиллагаа | - | Мэдээллийн системийн хэвийн ажиллагаа хангагдсан байна. | Үндэсний дата төв болон Биеийн тамир, спортын улсын хороо хооронд байгуулсан 2024 оны ЗС/24-272/03 дугаартай гэрээний хүрээнд mcloud.gov.mn системд байгууллагын хэрэглэгчийн эрхийг үүсгэн 4 ширхэг зохиомол серверийг үүсгэн шаардлагатай тохиргоог хийж ажиллалаа.<br>Үндэсний дата төв болон Биеийн тамир, спортын улсын хороо хооронд байгуулсан 2024 оны ЦШДХ/24-271 дугаартай гэрээний дагуу бие бялдрын сорилын систем ажиллах soril.sport.gov.mn, салбарын улсын тооллогын мэдээллийн систем ажиллах toollogo.sport.gov.mn домэйний тохиргоог хийж, тус системүүдийг ашиглалтад оруулахтай холбоотой тохиргоог тухай бүр хийн ажиллалаа. | 01.01 – 12.31 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2.2. Салбарын мэдээллийн системийн мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэх | Эмзэг байдал үүссэн тохиолдлын тоо | Байгууллагын сүлжээнд эмзэг байдлын тохиолдол бүртгэгдсэн. | Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эмзэг байдлыг арилгасан байх | Иргэдийн бие бялдрын түвшин тодорхойлох сорилын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй 4 төвийн үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамжийн ажлын гүйцэтгэлийн явцтай танилцаж, тухайн программтай холбоотой мэдээллийн аюулгүй байдлын үзлэгийг зохион байгуулах хүсэлтийг Тагнуулын Ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй | 01.01 – 12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байдлын газарт албан бичгээр хүргүүлэн ажиллав.<br>Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвөөс 2025 оны 02 сарын 27-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд Үндэсний шигшээ багын https://sport.gov.mn/ веб хуудаст үйлдэгдсэн "web defacement" төрлийн кибер зөрчлийг илрүүлэв. Иймд тус зөрчилд хариу арга хэмжээ авч хэрхэн шийдвэрлэсэн талаар бидэнд эргэж мэдэгдэнэ үү.” Мэдээллийн дагуу хариу арга хэмжээг зохион байгуулж тухайн зөрчилд холбогдсон албан хаагчийн нэвтрэх нууц үгийг шаардлагад нийцүүлэн зассан.<br>Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвөөс 2025 оны 03 сарын 07-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн “Эмзэг байдлыг засварлаж ажиллах тухай” мэдээллийн төрөөр үүссэн эмзэг байдлыг шийдвэрлэн ажиллав. | | |
| 3. | Арга хэмжээ 2.3. Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн | Гэрээний хэрэгжилтийн хувь | Гэрээний хавсралтаар батлах ажлын хуваарь | Гэрээний хэрэгжилт хувь 70 | Байгууллагын даргын 2025 оны А/118 дугаар тушаалаар “Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн цахим сангийн | 04.15 – 12.31 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглалтын хэвийн ажиллагааг хангах, хөгжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлэх | | | | засвар, үйлчилгээ, хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх тухай” ажлыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Тус ажлын хүрээнд тухайн ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Худалдан авалтын ажил хийгдэх явцад улсын төсөвт тодотгол хийгдэн тус арга хэмжээг танасан.<br>Ингэснээр Байгууллагын даргын 2025 оны А/282 дугаар тушаалаар шийдвэрлэж, Биеийн тамир, спортын улсын хороо болон Идэа дэвэлопмент ХХК хооронд 228 дугаартай “2025 онд Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн мэдээллийн системүүдийн хэвийн ажиллагааг хангах болон хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулан цахим сангийн засвар үйлчилгээ, хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 2.4. Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн мэдээллийн сангаас төрийн үйлчилгээний e-mongolia.mn системд нийлүүлэх салбарын төрийн цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | Цахим үйлчилгээний тоо | E-Mongolia системд 1 үйлчилгээ нэвтэрсэн | Системийн хөгжүүлэлтийн ажлын эхлүүлсэн байх | Салбарын мэдээллийн системийн ашиглалтын сайжруулах зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Биеийн тамир, спортын улсын хорооны хооронд байгуулсан 2023 оны Д-2023/190 дугаартай “Танилт, нэвтрэлтийн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”, Х-2023/249 дугаартай “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу салбарын мэдээллийн системд Иргэний үнэмлэхийн мэдээлэл дамжуулах сервис, Иргэний хаягийн мэдээлэл дамжуулах сервисийг холбох ажлыг хамтран хэрэгжүүлэх хүсэлтийг хүргүүлэн ажиллав. | 04.10 – 12.31 | 40 |
| 5. | Арга хэмжээ 2.5. Агентлагийн байранд мэдээллийн аюулгүй байдлын шаардлагад нийцсэн серверийн өрөөг бий болгох | Шаардлагад нийцсэн өрөөтэй болсон байх | Хоосон өрөөтэй. | Тус ажлын гэрээний дагуу өрөөг хүлээн авч үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. | Тус арга хэмжээг байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулах санал өгсөн ч төсвийн хүрэлцээгүй байдлаас үүдэн танаж хэрэгжих боломжгүй болсон. | 03.01 – 12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Арга хэмжээ 2.6. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй Лицензтэй программ хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлж, мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг үе шаттайгаар бууруулна. | Нэмэгдүүлсэн лицензийн тоон үзүүлэлт | 7 хувь | 15 хувь | Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/354 дугаар тушаалаар шийдвэрлэж "ЭН ДИ АЙ" ХХК-тай 269 дугаартай гэрээг байгуулан ажиллаж, байгууллагын мэдээллийн сүлжээний хяналтын төхөөрөмжийн программ хангамжийн лицензийн сунгах арга хэмжээг зохион байгуулав.<br>Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй "Microsoft office 365" программ хангамжийн лиценз худалдан авахаар tender.gov.mn цахим хуудасны Цахим дэлгүүрт захиалга өгөн ажиллаж байна.<br>Байгууллагын албан хаагчийн компьютер, хэрэгсэлд хортой кодын эсрэг программ хангамжийг суулган ажиллав. | 03.01 – 12.15 | 100 |
| **ЗОРИЛТ 3.** "ЦАХИМ КОНТЕНТ, СУРГАЛТЫН ЦАХИМ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ, ТҮГЭЭХ, САЛБАРЫН БАЙГУУЛЛАГЫГ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАХ" | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | Худалдан авалт | - | Шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг хийгдсэн байна. | Байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны цахим хэлбэрийг дэмжих NAS серверийг худалдан авч, серверийг тохиргоо, хэрэглэгчдийн тохиргоог хийн байгууллагын баримт бичгийн аюулгүй байдлыг хантан ажиллав. | 03.01 – 12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 3.2. Харьяа байгууллагын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлт, үйл ажиллагааны ашиглалтыг нэгдсэн удирдлагаар хангаж, цахим сангийн асуудал хариуцан ажиллаж буй албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 2 удаагийн сургалт зохион байгуулсан байна. | Монгол Улсын Хүүхдийн өвлийн спортын VIII наадам, Монгол Улсын Хүүхдийн зуны спортын VIII наадмын хүрээнд "Тэмцээн, наадмын системд мэдээллийг бүрдүүлэх" сэдэвт сургалтыг салбарын хэмжээний харьяа байгууллагуудын мэдээллийн систем хариуцсан албан хаагчдыг хамруулан 2 удаа цахимаар зохион байгуулан ажиллалаа. | 01.01 – 12.15 | 100 |
| **ЗОРИЛТ 4.** "САЛБАРЫН ХЭМЖЭЭНД НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙГ БИЙ БОЛГОХ, ШИНЭЧЛЭХ, ОЛОН НИЙТЭД НИЙТЭД НЭЭЛТТЭЙГЭЭР АШИГЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ" | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1. Байгууллагын нээлттэй өгөгдлийг бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 100 | Биеийн тамир, спортын улсын хорооны нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. | 04.01 - 12.15 | 100 |
| 2. | Арга хэмжээ 4.2. Нээлттэй өгөгдөл шинээр бий болгох талаар санал гаргах, нээлттэй өгөгдөлтэй холбоотой хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэж, хариу өгөх | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт | - | Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна. | Нээлттэй өгөгдөлтэй холбоотой өргөдөл, гомдол, хүсэлт ирээгүй болно. | 01.01 - 12.15 | 100 |

| **ЗОРИЛТ 5.** "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 5.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн үнэлгээ | - | Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг тайлагнасан байна.<br>Мөн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаарх тайлан мэдээ тухай бүр тайлагнана. | Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж, гүйцэтгэлийн тайланг хагас жилээр нэгтгэн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган ажиллалаа.<br>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг сар бүр мэдээллийг тус тус нэгтгэн Төрийн захиргааны удирдлагын газарт тухай бүр хүргүүлэн ажилласан. | 01.01 – 12.15 | 100 |
| 2. | Арга хэмжээ 5.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Ирсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн гүйцэтгэл, явуулсан албан бичгийн тоо | - | Ирсэн албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэсэн байна. | Албан хэрэг хөтлөлтийн хүрээнд 2025 оны хагас жилийн байдлаар нийт 16 албан бичиг ирсэн ба тус албан бичгүүдийг удирдлагын заалт болон холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн ажиллалаа. Энэ хүрээнд хариутай албан бичгийн хариу болгон 10 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа. | 01.01 – 12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 5.3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Хөрөнгө орлогын мэдүүлэг, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, | - | Хөрөнгө орлогын мэдүүлгээ бөглөсөн байна. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах тохиолдолд мэдүүлсэн байна. | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд 2 сарын 15-ны өдрөөс өмнө хөрөнгө орлогын мэдүүлгийг бөглөн илгээсэн. Байгууллагын даргын 2025 оны "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/33, А/40, А/118 дугаар тушаалаар байгуулсан үнэлгээний хорооны даргаар ажиллах болсон тул ашиг, сонирхлын зөрчлийн мэдүүлэг тухай бүр бөглөн ажиллаж байна. | 01.01 – 12.15 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Худалдан авах ажиллагааны цахим системийн эрхийг хариуцах ажиллах | Худалдан авах ажиллагааны цахим системийн ажиллагаа | - | Худалдан авах ажиллагааны цахим системийн саатаалгүй ажиллагаа | Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалтууд тендерийн цахим системээр саадгүй хийгдэж байна. | 04.15 – 12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/33 дугаар тушаалаар Үнэлгээний хороонд ажиллах | Худалдан авалт амжилттай хэрэгжсэн байх | - | Захиалагчид зөвлөмж хүргүүлэх | Спортын төв ордны Харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо ажиллан дээрх 2 ажлыг зарласан. https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1746497380659 https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1746497382355 | 02.19 - 07.30 | 100 |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/40 дугаар тушаалаар Үнэлгээний хороонд ажиллах | Худалдан авалт амжилттай хэрэгжсэн байх | - | Захиалагчид зөвлөмж хүргүүлэх | Хүүхдийн спортын зуны VIII дугаар наадмын худалдан авалтыг амжилттай зохион байгуулан тус арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан. | 02.19 - 05.30 | 100 |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/43 дугаар тушаалаар Үнэлгээний хороонд ажиллах | Худалдан авалт амжилттай хэрэгжсэн байх | - | Захиалагчид зөвлөмж хүргүүлэх | Монгол Улсын биеийн тамир, спортын салбарын цогц стратеги боловсруулах олон улсын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хэрэгжүүлж байна. https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1746497374721 | 03.13 – 07.30 | 100 |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/118 дугаар тушаалаар Үнэлгээний хороонд ажиллах | Худалдан авалт амжилттай хэрэгжсэн байх | - | Захиалагчид зөвлөмж хүргүүлэх | “Компьютер техник хэрэгсэл худалдан авах тухай”, “Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн цахим сангийн засвар үйлчилгээ, хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх тухай” арга хэмжээг худалдан авах ажлын үнэлгээний хороо ажиллаж байна. | 04.25 – 07.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмын зохион байгуулах хороонд ажиллах | Наадмын зохион байгуулалт | - | Наадам амжилттай зохион байгуулагдсан байна. | Монголын хүүхдийн спортын зуны VIII наадамд даргын шийдвэрээр зохион байгууллагад оролцох | 03.01 – 06.15 | 100 |
| 7. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын А/305 дугаар тушаалаар "Архивын улсын үзлэгт бэлтгэх комисс байгуулах тухай" шийдвэрлэж тухай комиссын гишүүнээр ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилт | - | Төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр заасан 6 арга хэмжээний гүйцэтгэл хангагдсан байна. | Байгууллагын архивын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ хангамжийн лицензийн худалдан авах, нийт албан хаагчдын компьютерт хортой кодын эсрэг программ суурилуулах, техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, шаардлагатай засвар үйлчилгээг хийх ажлыг зохион байгуулсан. Байгууллагын цахим баримтын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор NAS сервер худалдан авч байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлэн шаардлагатай албан хаагчдыг тус серверийн хэрэглэгчээр бүртгэн үйл ажиллагааны хэвийн байдлыг хариуцан ажиллаж байна. Байгууллагын мэдээллийн сүлжээний хяналтын программын лицензийг сунган, мэдээллийн сүлжээний хяналтыг тухай бүр хийн ажиллаж, улсын үзлэгийн комисс ажиллах үеэр хариуцсан асуудлын хүрээнд тайлбар тодруулга өгч, авбал зохих оноогоо бүрэн авч ажилласан. | 10.01 – 10.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Байгууллагын дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн чөлөөлөгдсөн байгууллагын шилэн индексийн мэдээллийн системийн хөтлөлтийг хийх | Үнэлгээний хувь | - | Үнэлгээний хувийг 85 болгоно. | Байгууллагын шилэн индексийн мэдээллийг байршуулан shilen.gov.mn мэдээллийн системд байгууллагын дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтний эрхээр бүрдүүлэн тайлагнасан. | 09.15 – 12.15 | 75 |
| 9. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ хангамжийн хэвийн ажиллагааг хангах, үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх | | | | Байгууллагын цахим хурлын программ хангамжийн удирдлагын системийг хариуцан ажиллаж зохион байгуулалтын нэгжүүдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу цахим хурлын бэлтгэл хангаж ажиллав. | 09.15 – 12.30 | 100 |
| 10. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10. Байгууллагын даргын А/..... дугаар тушаалаар байгууллагын өмчийн талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт ажиллах | Түрээслэгчийг сонгох | - | Түрээслэгчийг сонгон шалгаруулсан байх | Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд 3 талбайг түрээслэх талбайн хувьд түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлыг хэрэгжүүлэн 2 талбайн түрээслэгчийг сонгон мэдэгдэл хүргүүлсэн бол 3 дахь талбайн түрээслэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. | 09.15 – 12.30 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн байгууллагаас зохион байгуулж буй төрийн албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамрагдана. | Сургалтын тоо | - | 1 сургалтад хамрагдсан байх | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Нийтийн албан тушаалтан нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад хамрагдав. | 01.01 – 12.15 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2. Төр ба төрийн бус байгууллагаас зохион байгуулах мэдээллийн технологийн чиглэлийн сургалтад хамрагдана. | Сургалтын тоо | - | 1 сургалтад хамрагдсан байх | И-Монгол академиас зохион байгуулсан төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас gov.mn системийн сургалтад хамрагдав. | 01.01 – 12.15 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Салбарын мэдээлэл, технологийн бодлогын зохицуулалт, аюулгүй байдал хариуцсан Ахлах мэргэжилтэн ................................ / Б.ЛХАГВАНЯМ / 2025 оны 12 дугаар сарын ..... -ны өдөр